



“ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ-3”ТӨХК-ИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг.Компанийн бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн хангалт, сургалт, бүтээмжийн талаар



2015 онд 994 ажилтантай үйл ажиллагаагаа явууллаа.



Өнөөдөр компаний нийт ажилтнуудын 51,6 % -г дээд болон тусгай дунд боловсролтой хүн эзэлж байна.

2015 оны ажлын үр дүнг товчхон дурьдвал:

- 2015 онд цахилгаан эрчим хүч түгээлтийн төлөвлөгөөг 100.8%-иар биелүүлэн ажиллаа. Дулааны ачаалал жил бүр өсөн нэмэгдэж байгаа энэ үед дулааны эрчим хүч түгээлтийн төлөвлөгөөг 107,8%-иар биелүүлж диспетчерийн графикайн зөрчилгүй ажиллалаа.
- Бүтээгдэхүүний борлуулалтын орлогын төлөвлөгөөг 103.6%-иар биелүүлж, 476,9 сая төгрөгийн ашигтай ажилласан.
- Төлөвлөсөнөөс дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчийг 2,1 нэгжээр, жишмэл түлшний хувийн зарцуулалтыг цахилгаанд 33,02 гр/кВтц, дулаанд 3,25 кг/Гкал- аар тус тус бууруулан ажилласан
- Авлагыг 3262,3 сая төгрөгөөр, нийт өглөгийг 4040,6 сая төгрөгөөр оны эхнээс тус тус бууруулсан
- Өртөг зардлыг бууруулах ажил зохион байгуулсанаар ЦЭХ-ний нэгжийн өөрийн өртөг төлөвлөсөнөөс 2,81 төгрөгөөр, ДЭХ-ний нэгжийн өөрийн өртөг 1145,2 төгрөгөөр буурсан.
- Хими цехэд усыг цэвэршүүлэх эсрэг осмосын технологийг амжилттай нэвтрүүлэн ажиллаа.
- 9-р зуухыг улсын төсвийн хөрөнгөөр сэргээн босгох ажлыг хийж дуусган туслах тоноглолыг явуулах, галлаж залгах туршилтын ажлууд хийгдэн улсын комисст хүлээлгэн өгсөн.
- Зуух №12, 13-ийн утаа сорогч болон үлээх салхилуурт давтамж хувиргагч суурилуулах ажил хийгдсэнээр ДХЦЭХ-ийг хэмнэж үр ашиг нэмэгдэнэ.
- Түлш дамжуулах цехэд Чех улсын буцалтгүй тусламжаар тоноглолын удирдлагыг автоматжуулах төслийг эхлүүлэн, 1,2-р шатны ажлыг хийж гүйцэтгэлээ.
- ЧУТ-ын ISO-9001 стандартыг хэрэгжүүлэх төслийн ажлыг амжилттай хэрэгжүүлэн олон улсын батламж авлаа.
- Албан бичиг эрхлэн явуулах e-office программыг хэрэгжүүлэх ажлыг амжилттай гүйцэтгэсэн болно.
- 2015 онд нийт 7 үндсэн тоноглолд их засвар хийхээр төлөвлөснөөс 7 үндсэн тоноглолд, 108 туслах тоноглолд их засвар хийхээр төлөвлөснөөс 108 туслах тоноглолд их засварын ажил гүйцэтгэж, үндсэн тоноглолын их засварын ажлын гүйцэтгэл 100%, туслах тоноглолын их засварын ажлын гүйцэтгэл 100% хийгдэж, өвлийн бэлтгэл ажлыг бүрэн ханган ажилласан.

“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК